



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 19 он 03 дугаар
сарын 01-ны өдөр

Дугаар 1987/493

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.ЦОГЗОЛМАА ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Хавдрын өвчлөлийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт: 8 хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

0002157

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Д.ОЮУНХОРОЛ НАРЫН НЭР БҮХИЙ
ГИШҮҮДЭЭС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД
ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

Асуулга 1. Салбарын бодлогын хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар

Хариулт. Дэлхий дахинд жилд 14.1 сая хүн шинээр хорт хавдраар өвчилж, 8.2 сая хүн хорт хавдрын улмаас нас барж, 32.6 сая хүн хорт хавдартай амьдарч байгаа бөгөөд хавдрын өвчлөл, нас баралтын талаас илүү хувь нь хөгжиж буй орнуудад бүртгэгдсэн байна¹.

Монгол Улсад 2018 оны байдлаар 6,073 хавдрын шинэ тохиолдол оношлогдож, 4412 хүн хорт хавдрын шалтгаанаар нас баржээ. Нийт хорт хавдраар оношлогдсон хүний 77% нь хожуу үе шатандаа буюу III, IV үедээ оношлогдож, аймаг, дүүрэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт 19 мянга гаруй хүн хорт хавдрын өвчний улмаас хяналтад байна.

Зонхилон тохиолдож буй хорт хавдрын нэгдүгээрт элэгний хорт хавдар 36.1%, хоёрдугаарт ходоодны хорт хавдар 14.8%, гуравдугаарт уушгины хорт хавдар 8.5%, дөрөвдүгээрт улаан хоолой хорт хавдар 6.4%, тавдугаарт умайн хүзүүний хорт хавдар 6.1%-аар тус тус эрэмбэлэгдэж байна. Эдгээр хавдрууд нийт хорт хавдрын өвчлөлийн 72.0 гаруй хувийг эзэлж байна.

Монгол Улсын хувьд хавдрын өвчлөлийг газар нутгийн байршлаар нь авч үзвэл, элэгний хорт хавдар Орхон, Өвөрхангай, Төв, Дорнод, Завхан аймагт, ходоодны хорт хавдар Орхон, Дархан-Уул, Увс, Сэлэнгэ, Хөвсгөл аймагт, уушгины хорт хавдар Төв, Өвөрхангай, Архангай, Орхон аймагт, Умайн хүзүүний хорт хавдар Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Хөвсгөл аймагт, улаан хоолойн хорт хавдар Баян-Өлгий, Увс, Ховд, Сэлэнгэ, Дархан-Уул аймагт өндөр байна.

Хорт хавдрын өвчлөл, нас баралт цаашид нийгмийн хөгжил, хүний амьдралын хэв маяг, хүрээлэн байгаа орчны бохирдол, насжилт гэх мэт олон хүчин зүйлээс нэмэгдэх хандлагатайг урьдчилан тооцоолж, улс орон бүр үндэсний түвшинд өнөөгийн бодит байдлаа бодитой үнэлж, хүн хүч эдийн засгийн нөөцийг зохистой хуваарилан, хавдрыг эрт шатанд нь илрүүлж, нэн шаардлагатай эмийн бодлого, хөнгөвчлөх тусламжийг хавдрын тусламж, үйлчилгээний салшгүй нэг хэсэг болгох, орчин үеийн жишигт нийцсэн үйлчлүүлэгчдэд ээлтэй оношилгоо, эмчилгээг өргөжүүлж чадвал хөрөнгө нөөц хязгаарлагдмал оронд ч илүү их үр дүнд хүрч болно гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас томьёолсон байна.

Монгол улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхээр *"Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д 10,000 хүн амд ногдох хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 10.5 хүртэл бууруулах* зорилго тавьж Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, "Халдварт бус өвчинтэй тэмцэх", "Элэг бүтэн Монгол" үндэсний хөтөлбөрүүд"- үүдийг боловсруулан, хэрэгжүүлж, хавдрын шалтгаант нас баралтыг

¹ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээллээр

бууруулахад чиглэн, өвчнийг аль болох эрт илрүүлэх, хувь хүний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааг тэргүүлэх чиглэлээ болгон, эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, шинэ дэвшилтэд технологийг нэвтрүүлэхэд онцгой анхаарал хандуулж, эрх зүйн болон зохион байгуулалтыг шинэчлэлийг шат дараатай хийж байна.

Хавдар судлалын үндэсний төвийн ачааллыг бууруулах, төвлөрлийг сааруулах, хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний чадавхийг орон нутгийн түвшинд сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

➤ Эмчилгээний шинэ арга техникийн талаар цаг алдалгүй мэдээлэл солилцох зорилгоор “Момент” төслийг хэрэгжүүлж алсын зайн дэд бүтэц бүхий онко-телемедициний тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулан эмч, мэргэжилтнүүдийг алсын зайн сургалтаар тасралтгүй сургаж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

➤ Эрхтэн шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Донорын тухай” хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар батлуулж, тархины үхэлтэй донороос эрхтэн шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж, иргэний эмчилгээ, үйлчилгээ авахтай холбоотой санхүүгийн хүндрэлийг бууруулахад чиглэн эрхтэн шилжүүлэн суулгах хагалгааны зардлыг хамтын төлбөрийн зарчмаар тодорхой хувийг улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна.

Түүнчлэн Хавдар судлалын үндэсний төв элэгний анхдагч өмөнтэй өвчтөнд амьд донороос элэг шилжүүлэн суулгах мэс заслын технологийг нэвтрүүлж 9 хүнд хагалгааг амжилттай хийсэн байна.

➤ Мөн элэгний хавдрыг бичил долгионоор түлэх /MWA/, бамбай булчирхайн хоргүй хавдар, зангилааг радио давтамжаар түлэх, багалзуурын дахисан хавдарт залгиур багалзуурын цагираг тайралт хийх гэх мэт 20 гаруй эмчилгээний технологиудыг шинээр нэвтрүүлээд байна. Үүний үр дүнд Хавдар судлалын үндэсний төвийн эмчилгээ, үйлчилгээний чанарт дэвшил гарч, жилдээ 2859 гаруй том хэмжээний мэс засал хийж байгаа бөгөөд хагалгааны дараах нас баралт 1.8%-тай байгаа нь дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын үзүүлэлттэй ижил хэмжээнд байна.

➤ Удахгүй ашиглалтад хүлээн авах Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулагдсанаар Монгол улс удаа бүтцийн өөрчлөлтийг илрүүлэх ПИТ СТ томографийн аппараттай болж зүрх, судас, мэдрэлийн өвчинг эрт үед нь оношлохоос гадна, хавдрын тархалт, үе шатыг нарийвчлан тогтоох эмчилгээний үр дүнг хянах боломж нэмэгдэх юм. Ингэснээр гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчилгээнд илгээж байгаа өвчлөлийг бууруулах юм.

➤ Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласан. Энэ нь ДЭМБ-аас Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэхэд “Хүн төвтэй тусламж үйлчилгээ”-г нэвтрүүлэхийг улс орнуудад зөвлөмж болгож байгаатай нийцэж байгаа юм. Тиймээс 2019 онд Эрүүл мэндийн салбартаа “Инээмсэглэл–Эерэг хандлага” уриаг дэвшүүлэн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ эмнэлгийн ажилтны ёс зүйг чандлан сахиж “Эмнэлгийн ажилтан-үйлчлүүлэгч-ар гэр”

гэсэн 3 талт харилцааг дээдэлж, бие, биедээ хүндэтгэлтэй хандаж ажиллах уриалга гаргаад байна.

➤ Мөн Эрүүл мэндийн яамнаас эрүүл мэндийн салбарт 2019-2020 онд хэрэгжүүлэх 8 зорилтыг багтаасан “Эрүүл мэнд-8/20” зорилтыг хэрэгжүүлнэ. Зорилтын гол зорилго нь “Хүн амын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн тогтолцоог бүрдүүлэн, санхүүгийн дарамтгүй, чанартай тусламж, үйлчилгээг үзүүлж Монгол хүний дундаж наслалтыг 71-д хүргэх” юм. Зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд “Зонхилон тохиолдох хорт хавдрын эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх” зорилтыг дэвшүүлж, эрт илрүүлгийн үзлэгийг эрүүл мэндийн байгууллагын түвшинд тогтмолжуулж, хэвшүүлэхэд онцгойлон анхаарлаа хандуулж ажиллахаар төлөвлөөд байна.

Асуулга 2. Хорт хавдрын эрт илрүүлэлт, үзлэгийн цар хүрээг нэмэгдүүлэхэд тулгамдаж байгаа асуудал

Хариулт. Хавдрын эрт илрүүлгийг оновчтой зохион байгуулж, хамрагдалтыг нэмэгдүүлснээр хорт хавдрын төгс эмчлэх боломжийг бүрдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлж, амьдрах хугацааг уртасгахын үндэс юм.

Монгол Улсын хувьд 2012 оноос хорт хавдрын эрт илрүүлгийн тогтолцоог бий болгож, нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжигч байгууллагуудтай хавдрын эрт илрүүлгийг идэвхтэй зохион байгуулах, зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч байна. Үүнд:

➤ Хавдар судлалын үндэсний төвийн бүтцэд 2017 оноос хорт хавдрын бүртгэл-тандалт, хорт хавдрын эрт илрүүлэг хариуцсан үндсэн 2 чиглэлийн алба байгуулагдсанаар үндэсний хэмжээнд хорт хавдрын эрт илрүүлэг, өвчлөл, нас баралтын мэдээг авч нэгтгэн боловсруулж, шийдвэр гаргагч нарыг мэдээллээр ханган ажиллахаас гадна мэргэжил арга зүйгээр дэмжлэг үзүүлэх, олон улсын байгууллагатай хамтарсан судалгаа шинжилгээ хийх бүрэн боломж бүрдсэн юм.

➤ Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан, товлोल, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн багцыг баталж, тогтвортой тогтолцоо бий болгосон. Энэхүү товлोल, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн багцын хүрээнд 30 наснаас эхлэн нас, хүйсийн онцлогт нийцүүлж, элэг, бүдүүн шулуун гэдэс, ходоод, хөх, умайн хүзүү, түрүү булчирхайн хавдрын эрт илрүүлэгт Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр үнэ төлбөргүй хамрагдах боломж бүрдсэн. Энэхүү үйл ажиллагаа хэрэгжиж эхэлснээс хойших 2 сарын хугацаанд 52 000 гаруй иргэн үзлэг, шинжилгээнд хамрагдсан байна. Нийт үзлэгийн 67% (35,135) эмэгтэйчүүд давамгайлж, эрэгтэйчүүд 33% (178351)-тай байна. Үүнээс насны бүлгээр ангилахад 46-64 насны эмэгтэйчүүдийн хамрагдалт хамгийн өндөр буюу 29%-тай байна.

➤ Халдварт бус өвчнийг бууруулах чиглэлээр хүн амын дунд зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, архи тамхины хэрэглээг бууруулах ард иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн сургалт сурталчилгааг сайжруулах чиглэлээр эрс шинэчлэл хийж, 50 гаруй хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй тогтмол хамтран ажиллалаа. Нийт 5 телевизээр “Эрүүл мэнд–Эрхэм баян” нэвтрүүлэг, өдөр тутмын сонинд “Эрүүл мэнд –Эрхэм баян” булан, нийгмийн сүлжээнд “Эрүүл мэнд–

“Эрхэм баян” фэйсбүүк хуудсыг тогтмол ажиллуулж иргэдэд эрүүл мэндийн боловсрол, мэдлэг, олгох, төрөлжсөн мэргэшлийн эмч нарын зөвөлгөө өгөх, ярилцлага хийх, урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн инфо график, посторыг давхардсан тоогоор 2000 гаруй удаа байршуулан түгээлээ. “Эрүүл мэнд –Эрхэм баян” фэйсбүүк хуудас жилийн хугацаанд 21 мянга гаруй гишүүнтэй болж эрүүл мэндийн чиглэлээрх хандалт өндөртэй пэйж хуудсуудын нэг болж чадлаа.

Мөн Хавдар судлалын үндэсний төв, Хаан банк, МҮОНРТ-тэй хамтран “Хавдрын эсрэг Үндэсний аян”-ыг 8 жил тасралтгүй зохион байгуулж, нийт 115,365 хүнийг эрт илрүүлэг үзлэгт хамруулж, 537 хорт хавдрыг илрүүлэн оношилж, орон нутагт 477 мэс засал хийж, сум, аймаг, дүүргийн 9,000 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сайн дурын идэвхтнийг сургалтанд хамруулаад байна.

➤ Эрүүл зан үйлийг хүүхдэд багаас нь эзэмшүүлэх, тэдэнд эрүүл мэндийн боловсролыг олгох үйл ажиллагааг бусад шинжлэх ухааны нэгэн адил бие даан сургалтын хөтөлбөрт орууллаа.

Элэгний вирусээс үүдэлтэй элэгний архаг үрэвсэл, хатуурал, хорт хавдрын шалтгаант нас баралтыг эрс бууруулах зорилго бүхий “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг 2017 оноос хэрэгжүүлж, хорт хавдрын эрт илрүүлгийг хамтатгасны үр дүнд ХСҮТ-д эрт үеийн буюу 3 см хүртэлх элэгний хорт хавдрыг түлэх (RFA) эмчилгээнд 2008 онд 20 хүн хамрагдаж байсан бол 2017 онд 723 иргэн хамрагдсан байна. Дашрамд дурдахад энэхүү хөтөлбөр нь “Дэлхий загвар хөтөлбөр” болсныг ДЭМБ сайшааж, Хепатитийн дэлхийн өдрийг “Илрүүлье - эмчилье” уриан дор манай улсад анх удаа зохион байгуулсан.

Сүүлийн жилүүдэд хавдрын шинэ тохиолдол нэмэгдэж, хорт хавдрын өвөрмөц эмчилгээ болох мэс засал, туяа, хими эмчилгээний эрэлт, хэрэгцээ ойрын жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, улсын хэмжээнд эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулалт, мэдээлэл сурталчилгааг сайжруулснаар хавдрын эрт үед оношлогдсон өвчтөний тоо нэмэгдэж, ХСҮТ-ийн ачаалал 25-30 хувиар нэмэгдэнэ гэж урьдчилан тооцоолж байна.

Иймд хавдрын эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх хүрээнд Япон Улсын Засгийн Газрын Төслийн бус буцалтгүй тусламжаар (FY2014) тус бүр нь 8,875,000 иен буюу 198,0 сая төгрөгийн үнэтэй 34 ширхэг Хэт авиан оношилгооны аппарат, 42,800,000 иен буюу 957,0 сая төгрөгийн үнэтэй дижитал зөөврийн рентген /с-агм/ аппаратаар 21 Аймаг, 9 дүүргийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төвийг хангахаар шийдвэрлээд байна. Мөн НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр 68,500 ам долларын үнэ бүхий Телемедицины яаралтай харилцах нэгжийн мэдээлэл технологийн төхөөрөмжийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдэд олгоно.

Цаашид хүний папиллома вирусийн эсрэг вакциныг үндэсний дархлаажуулалтын товлонд оруулах, мэдээлэл сурталчилгаа, түүнд зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд анхаарч байна.

Асуулга 3. Хорт хавдрын эмчилгээний чанар, хүчин чадал, хүртээмж, төсөв санхүүгийн талаар:

Хариулт. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага болох өрх, сумын эрүүл мэндийн төвийн хорт хавдраас урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох, эрт илрүүлэг, оношилгооны чадавхийг сайжруулахад чиглэсэн мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэхэд онцгой анхаарч нэг хүнд ногдох зардал, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, санхүүжилтийг нэмэгдүүлэх шийдлүүдийг гаргалаа.

“Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-г шинэчлэн хорт хавдрын эсрэг үйлчилгээтэй 3 эмийг 50 хувийн хөнгөлөлттэйгөөр авах боломжийг бүрдүүлж, жор бичих эрх бүхий эмч, эмийн сан, даатгуулагч, даатгалын байгууллагын үйл ажиллагаанд цахим жорын тогтолцоог нэвтрүүлэв. Ингэснээр даатгуулагч шаардлагатай үедээ эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг хүндрэл бэрхшээлгүйгээр авах боломжоор хангагдаж, эмийн хүртээмж нэмэгдсэн.

ХСҮТ-ийн хими эмчилгээний тасаг нь хэвтэн эмчлүүлэх 20 ортой тасагт 7 хоногт 42-50 хүн, өдрийн эмчилгээний 13 ор бүхий хэсэгт өдөрт дунджаар 30-35 хүн (зарим үед 40 гаруй хүн эмчлэгддэг), амбулаторийн үзлэгийн 2 кабинетэд өдөрт 32-50 хүнд үзлэг, оношилгоо, эмчилгээ хийгддэг. Хорт хавдраар өвчлөгсдөд 7 их эмч, 14 сувилагч, 1 туслах ажилтантайгаар мэс заслын өмнө болон дараах эмчилгээ хийдэг. Мөн хөнгөвчлөх зорилгоор химийн эмчилгээ хийдэг.

Жилээс жилд хавдрын өвчлөл ихэсч байгаагаас шалтгаалан химийн эмчилгээнд хамрагдах үйлчлүүлэгчийн тоо ч нэмэгдэж байгаа бөгөөд 10 жилийн өмнөхтэй харьцуулахад хими эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 64%-аар, амбулаториор үйлчлүүлэгсдийн тоо 69%-аар өссөн байна.

Тухайлбал, химийн амбулаторийн үзлэгийн кабинетаар 2012 онд 5887 хүн үзүүлж байсан бол 2018 онд 7503, хэвтүүлэн эмчлүүлэх тасгаар 2012 онд 3538 эмчлэгдэж байсан бол 2018 онд 5232 болж өссөн. Орны тоо, хүний нөөц нэмэгдээгүйн улмаас өдрийн эмчилгээний хэсэг ачааллаа дийлэхгүй эмчилгээ шөнө дунд хүртэл үргэлжлэх, хэвтүүлэн эмчлэх тасгийн 20 оронд дунджаар 21 хоногоос 1 сар орчим хугацаанд байнгын хүлээгдэл үүсгэн товлот эмчилгээний горим алдагдаж эмчлүүлэгчид үйлчлүүлэгчдийг чирэгдүүлэн бухимдуулахад хүргэж байна. Химийн эмчилгээний явцад болон дараа нь зарим тохиолдолд эрхтэн системийн талаас хүндрэл гарч болдог ба энэ тохиолдолд эмчлүүлэгчийн хэвтэх хугацаа уртсахын хэрээр орны хүлээгдэл даган нэмэгддэг.

Хавдрын хими эмчилгээний төвлөрлийг сааруулах, хүлээгдэл чирэгдлийг багасгах зорилгоор орон нутаг, дүүргийн эмнэлэгт тус эмчилгээг хийх чадамжийг бүрдүүлэхэд чиглэн хавдар судлаач эмч нарыг химийн эмчээр мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж мэргэшүүлэн төгсгөсөн.

Мөн санхүүжилтийн бэрхшээлийг арилгах, аймаг дүүрэгт хими эмчилгээг хийлгэхэд шаардагдах санхүүжилтийг бий болгох зорилгоор 2016 оноос ЭМД-ын

сангаас хими эмчилгээний нэг тохиолдлыг 450 000 төгрөгийн өртгөөр санхүүжих эрх зүйн орчныг бий болгосон.

Гэвч бэлтгэсэн эмч мэргэжилтний ажлын байрыг өөрчлөн өөр ажилд шилжүүлэх, химийн хортой эм бэлдмэлтэй харьцдаг боловч хэвийн бус нөхцөлд хамруулдаггүй зэрэг олон шалтгаанаас бэлтгэгдсэн эмч мэргэжилтнүүд мэргэжлээрээ ажиллах сонирхолгүй болж, ажлаас гарах зэрэг бэрхшээл тулгарч байна. 2018 оны жилийн эцсийн мэдээгээр Булган, Говь-Сүмбэр, Дархан-Уул, Сэлэнгэ, Дундговь, Завхан, Өвөрхангай, Төв, Хэнтий аймгуудад химийн эмчилгээ хийхгүй байна.

Харин Сонгинохайрхан, Баянгол, Хан-Уул, Найлайх, Багануур, Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн байгууллага хавдрын химийн эмчилгээ хийж эхэлсэн ба Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүд хими эмчилгээ хийхэд бэлэн болсон байна. Одоогоор дүүргүүдэд химийн эмчилгээний 28 ор ажиллаж байна. Үүний үр дүнд төвлөрлийг сааруулж, ачааллыг бууруулан үйлчлүүлэгчдийг товлोलт эмчилгээнд чирэгдэлгүй орох боломж, бүрдсэн боловч 2018 оны сүүлээр орон нутаг, дүүргүүдийн эмийн төсвийн хүрэлцээгүйн улмаас эм, тарианы хангалт дутмаг, цаашлаад эмчилгээний өндөр үр дүнтэй, өндөр технологийн эмийн санхүүжилт хангалтгүй байгаагаас шалтгаалж ХСҮТ-ийг зорин ирэх урсгал багасахгүй байна.

Сүүлийн 10 жилд ХСҮТ-ийн оношилгоонд хамрагдсан хүний тоог 2007 онтой харьцуулахад 56 хувиар, лабораторийн шинжилгээний нэгжийн тоо 41% нэмэгдсэн байна. Хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 2.3 дахин өссөн бөгөөд жилд 2,590 мэс засал хийгдэж байна. Амбулаториор өдөрт дунджаар 500 орчим үйлчлүүлэгч ханддаг бөгөөд ар гэрийн 2-3 гишүүд заавал дагаж үйлчлүүлж байна.

Өнөөгийн байдлаар тус төвөөр үйлчлүүлэх шаардлагатай өвчтөнүүдийн хүлээлгийн дундаж хугацаа 3-4 долоо хоног, зайлшгүй мэс засалд орох шаардлагатай өвчтөний хүлээлгийн хугацаа 14-30 хоногтой байгаа нь өдөр өдрөөр өсөн томорч тархах хорт хавдрыг ялан давах, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна. Мөн хавдрын тусламж үйлчилгээг авахаар гадаадын улс орнуудруу зорчигчдын тоо, зардал ч өндөр хэвээр байсаар байна.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээ авахтай холбоотой санхүүгийн хүндрэлийг бууруулах зорилгоор өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн өртгийн 75 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх шийдвэр гаргасан нь иргэдийг эрүүл мэндийн эдийн засгийн хямрал, оруулахаас сэргийлэх алхам болсон. Энэхүү хөнгөлөгдөх мэс заслын жагсаалтад хавдрын 61 мэс заслын хэрэгсэл багтдаг бөгөөд 2017, 2018 онд хавдрын мэс заслын хагалгаанд орсон нийт 5336 хүнд 6 тэрбум 832 сая, 228 мянга төгрөгийн хөнгөлөлтийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр үзүүлсэн байна.

Асуулга 4. Хүний нөөц, цалин урамшуулал ажиллах орчны талаар

Хариулт. 2017 оны эрүүл мэндийн статистик мэдээллээр улсын хэмжээнд хавдрын төрөлжсөн мэргэшлийн их эмч 60, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний их эмч 33, хавдрын мэргэшсэн сувилагч 85, хөнгөвчлөх эмчилгээний сувилагч 55 ажиллаж байна.

Хавдар судлалын үндэсний төв 2000 оноос хойш хавдрын мэргэшлээр төгсөлтийн дараах сургалтанд 150 гаруй эмчийг сургасан хэдий ч орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаа нь ачаалал их, хавсран ажил гүйцэтгэдэг зэргээс шалтгаалж байна. Түүнчлэн сүүлийн 5 жилд давхардсан тоогоор 410 гаруй эмч, мэргэжилтэнг ХСҮТ өөрийн нөөц бололцоо болон Олон улсын цөмийн энергийн агентлаг бусад дэмжигч байгууллагын дэмжлэгтэйгээр АНУ, Япон, БНСУ, Тайвань, Энэтхэг, БНХАУ, Швейцар, Франц, Канад, Австри, Герман, Сингапур зэрэг өндөр хөгжилтэй улс оронд 14 хоногоос 1 жил хүртэл хугацаагаар суралцаж мэргэжил дээшлүүлсэн.

Мөн гадаадын өндөр хөгжилтэй оронд улсын төсвийн санхүүжилтээр 2018 онд мөч хадгалах боломжтой үеийн яс, зөөлөн эдийн хавдрын нөхөн сэргээх мэс засал, хавдрын химийн бай эмчилгээ, хими эмчилгээний хордлогын хүндрэлийн эмчилгээ, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгооны чиглэлээр нийт 6 эмнэлгийн мэргэжилтэнг сургасан байна. Түүнчлэн хүүхдийн хавдрын мэс заслын эмч, эрчимт эмчилгээний эмчийг БНЭУ, эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын чиглэлээр багаар нь буюу нийт 15 эмч, сувилагчийг БНСУ-ын Самсунг эмнэлэгт сургасан.

Энэ онд яс зөөлөн эдийн хавдрын нөхөн сэргээх мэс засал, эрхтэн шилжүүлэн суулгасны дараах дархлаа тогтолцооны хяналт, эмчилгээний үр дүнг тооцох чиглэлээр нийт 10 эмнэлгийн мэргэжилтэнг сургах бэлтгэл ажлыг хангаад байна.

Тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, сувилагч нарын тоог нэмэгдүүлэх зорилгоор 232 сувилагчийг давтан сургалтанд төрийн санхүүжилтээр хамруулан, тэдний 77 хувийг нь ажлын байраар хангаад байна. Тодруулбал, Хавдар судлалын үндэсний төв сүүлийн 2 жилийн хугацаанд 43 хавдрын сувилагчийн орон тоог нэмсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сард гарсан “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл”-ийг шинэчлэн тогтоосон шийдвэрийн хүрээнд эмч, сувилагч нар шатлал, нийслэл, орон нутаг харгалзахгүй цалин ижил авдаг болсноор тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлсэн.

Эрүүл мэндийн ажилтныг мэргэжлийн ур чадвар, хариуцлага, хөдөлмөрийн нөхцөлийг харгалзан ажлын байрны үнэлгээнд суурилсан цалингийн тогтолцоог нэвтрүүлж сувилагчийн цалингийн хэмжээг 127.0 мянгаас 183.0 мянган төгрөг буюу 20-30 хувиар нэмэгдүүлж, цалингийн ангилал, зэрэглэлийг 1-2 шатлалаар ахиуллаа.

Асуулга 5. Эмнэлгийн тоног төхөөрөмж, байр талбайн хүртээмж, чанарын талаар

Хариулт. Хавдрын чиглэлээр төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болох Хавдар судлалын үндэсний төв нь улсын хэмжээнд хавдрын мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, улсын хэмжээнд бусад эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэгтэй юм.

Хавдар судлалын үндэсний төв нь 3 клиник, хэвтүүлэн эмчлэх 275 ор бүхий 11 тасагтай, удирдах ажилтан 3, их эмч 120, бага эмч 5, эмзүйч 10, сувилагч 185, хөдөлгөөн засалч 3, лаборант 17, техникч 16, эм найруулагч 4, туслах сувилагч 14, ариутгагч 5, дээд мэргэжилтэн 53, үйлчлэгч 72, бусад ажилтан 56, нийт 563 орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна.

ХСҮТ нь нийт 563 нэр төрлийн аппараттай бөгөөд 80-90% нь бүрэн ашиглагдаг. 1-5 жил ажиллаж байгаа аппарат нийт аппаратын 0,7%-ыг, 5 аас дээш жил ажиллаж байгаа аппарат нийт аппаратын 89,3%, насжилт өндөртэй буюу 10 дээш жил ажиллаж байгаа аппарат нийт аппаратын 9,9% эзэлж байна.

Хавдрын өвөрмөц эмчилгээ болох хими болон туяа эмчилгээг 2016 онд 5314, 2018 онд 5928 хүн үйлчлүүлсэн бөгөөд эмчилгээг тодорхой давтамжтай олон удаа хийдэг онцлогтой. Хөдөө орон нутгаас ирж эмчлүүлж байгаа өвчтөний хувьд хэвтэх орны хүлээгдлээс болж эмчилгээ хугацаандаа хийгдэхгүй цаг алдах, өдрөөр эмчилгээ хийлгэх тохиолдолд мэргэжлийн асаргаа сувилгаа дутагдах, хотод байрлах байргүйгээс эмчлүүлэгчийн сэтгэл зүйн байдалд сөрөг нөлөөлж, улмаар эмчилгээний үр дүнд муугаар нөлөөлж байна.

Тус төвийн одоогийн ашиглаж байгаа барилга 1981 онд ашиглалтанд орж байх үед Монгол улсын хүн ам 1,595,006 байсан бол өнөөдөр 3,119,935 болоод байна.

Хорт хавдрыг тусламж, үйлчилгээг өргөжүүлэхэд ХСҮТ-ийг түшиглэн орчин үеийн өндөр хөгжилтэй орны стандартыг хангасан эмнэлгийн барилгатай болох боломж хамтын ажиллагааг идэвхтэй эрэлхийлэн ажиллаж байна.

Эрүүл мэндийн дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг, хавдрын тусламж, үйлчилгээний нөхцөл байдлыг тодорхойлон, шийдвэрлэх гарцыг тодорхойлж, Монгол Улсын Засгийн Газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Засгийн газрын хуралдааны шийдвэрийн дагуу байршлын хувьд тохиромжтой, эмнэлгийн урсгал стандартад нийцсэн, шинээр эмнэлгийн зориулалтын барилга барих цаг хугацааг хэмнэх давуу талтай "Энэр мед" ХХК-ийн барьж буй эмнэлгийн барилгыг концессын гэрээгээр ХСҮТ-ийн үйл ажиллагаанд өргөтгөн ашиглах урьдчилсан нөхцөл байдлыг судлан санал боловсруулж, танилцуулж шийдвэрлүүлэх ажлыг Барилга хот байгуулалтын сайдтай хамтарсан ажлын хэсэг байгуулан судалж байна.

Түүнчлэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын хавдрын эрт илрүүлэгт шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаанаас харахад ходоод, бүдүүн гэдэсний дуран болон дагалдах ариутгал халдваргүйжүүлэлтийн стандартад нийцсэн иж бүрдэл дутагдалтай байгаа бөгөөд тоног төхөөрөмжийн шинэчлэл, нийлүүлэлтэд шаардлагатай хөрөнгө санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

-----oOo-----